



**БУЛГАН АЙМГИЙН  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082  
Утас/Факс: 7034-2580  
E-mail: bulgan@audit.gov.mn

2024.08.19 № 823  
танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

БУЛГАН АЙМГИЙН БАЯН-АГТ  
СУМЫН СОНГУУЛИЙН ХОРООНД

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн  
талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Баян-Агт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч иргэн Ж.Сүхболдийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа,

006021348

мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.


### Дүгнэлт

Бие даан нэр дэвшигч иргэн Ж.Сүхболд Баян-Агт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч иргэн Ж.Сүхболдийн мөрийн хөтөлбөр (...../.....хуудас)-ийг хавсаргав

Хувийг: Бие даан нэр дэвшигч иргэн Ж.Сүхболдод

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

БУЛГАН АЙМГИЙН БАЯН-АГТ СУМЫН ХҮРЭМТ БАГИЙН 2024 ОНЫ ИТХ-ЫН  
СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ Ж. СҮХБОЛДЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

**1. Боловсрол**

- 1.1 Хамран сурах сурагчийн тоог нэмэгдүүлэх бодлогыг баримтална
- 1.2 Жил бүр нэг ангийг тохижуулж тоног төхөөрөмжөөр хангах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ
- 1.3 Монгол бичгээр уншиж бичиж чадвартай иргэдийн судалгааг гаргаж унших чадварыг сайжруулах
- 1.4 Математик, англи хэлний хичээлийн чанар хүртээмжийг нэмэгдүүлэх

**2. Эрүүл мэнд**

- 2.1 3-14 насны хүүхдийг шүдний үзлэгт тогтмол хамруулж шүдний өвчлөлөөс урьдчилан сэргийлэх
- 2.2 Сумын төвийн ард иргэдийг тогтмол үзлэгт хамруулахыг уриалах
- 2.3 Идэвхтэй хөдөлгөөний ач тусыг таниулж, хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх
- 2.4 Архи, тамхины хэрэглээг багасгах, татгалзах, хор хөнөөлийг таниулах

**3. Жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ**

- 3.1 Арьс нэхий элдэх сонирхолтой ард иргэдийн үйл ажиллагааг дэмжин ажиллах
- 3.2 Гар урлалын үйлчилгээний чанар хийц дээр анхаарах
- 3.3 Сумын хэрэгцээг хангаж чадахуйц гурилын цехтэй болохыг эрхий бүхий удирдлагад уламжлах
- 3.4 Ард иргэдийг төмс хүнсний ногоо тариалж худалдан борлуулалт хийх үйл ажиллагааг сайжруулах
- 3.5 Өрх бүрийг төрөл бүрийн жимс жимсгэний мод тарихыг уриалж ажиллах
- 3.6 Тахианы аж ахуйг үйл ажиллагааг сайжруулах, хамтран ажиллах

**4. Байгаль орчин, аюулгүй байдал**

- 4.1 Сумын төвийн ойр орчмын булаг шандыг хашиж мод тарьж урсацыг нэмэгдүүлэх тал дээр хяналт тавих
- 4.2 Байгууллагын орчмын ногоон байгууламжийг сайжруулах дээр төрийн байгууллага, аж ахуй нэгжтэй хамтран ажиллах
- 4.3 Сумын төвийн хогийн цэгийн салхин доод тал мод тарихыг уриалах
- 4.4 Ойн нөхөрлөлийн үйл ажиллагааг анхаарч ажиллах
- 4.5 Айл өрхийн цахилгааны монтажийг сайжруулах, галын аюулгүй байдал дээр хяналт тавьж зөвлөгөө өгөх,
- 4.6 Сумын төвийн камержуулалтыг нэмэх, сайжруулахыг шаардах
- 4.7 Сумын төвийн гудамны гэрэлтүүлгийг сайжруулахыг шаардах

Мөрийн хөтөлбөр боловсруулсан: Жамбалсүрэн Сүхболд

Холбоо барих утас: 99624294

Gmail: jambalsurensuhbold3@gmail.com